



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/18

Арвайхээр сум

Газар эзэмших эрх нэгтгэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 8.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын инженерийн шугам сүлжээ бүхий газарт байрлах 2 нэгж талбарыг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хавсралтад зааснаар газар эзэмших эрхийг нэгтгэсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн "Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай" А/510 дугаар захирамжийн хавсралтын Ж.Самданжигмэдтэй холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0037

Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дугаар сарын 17-ны өдрийн 7/18 дүгээр захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ НЭГТГЭЖ БУЙ НЭГЖ ТАЛБАРЫН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²)	Нэгж талбарын дугаар	Газар эзэмших эрх шилжүүлэн авагчийн овог, нэр (Хуулийн этгээдийн нэр)	Эрх шилжүүлэн эзэмшигчийн регистрийн дугаар	Газрын зориулалт	Газрын хэмжээ (м ²) Газрыг	Газрын байршлын нэр, хаяг	Эзэмших хугацаа
1	Ж.Самданжигмэд	ЙЮ60121697	9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	677	6216030818	Ж.Самданжигмэд	ЙЮ60121697	9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	2449	13 дугаар баг, Д.Пүрэвдорж-8 гудамж, 850 тоот	42 жил
2	Ж.Самданжигмэд	ЙЮ60121697	9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууц	1772	6216035982						